

ТАНИЛЦУУЛГА

“Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9 дэх заалтад “хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх” гэж, мөн хуулийн 16.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 4.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөнө” гэж тус тус заасан. Дээрх хуулийн заалттай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 24 дүгээр зүйлд “24.1.6.Малчны тухай хуульд заасан бол” гэсэн агуулга бүхий заалт нэмсэн.

Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна” гэж заасан.

Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл болон журмын төслийг боловсрууллаа.

Малчны тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх, орлогыг төвлөрүүлэх, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, тайлагнах, шимтгэл нөхөн төлсөн хугацааг хянан баталгаажуулах харилцааг зохицуулахад оршино.

Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9-д заасан, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас өндөр насны тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгоогүй, 1995-2025 онд малчнаар ажиллаж байсан болон ажиллаж байгаа, 10-аас дээш жил шимтгэл төлсөн малчин даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг 5 хүртэл жилээр нэг удаа нөхөн төлүүлнэ.

Малчны тухай хуулийн дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлийг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 5 хүртэл жилээр тооцон төлүүлэхэд 20.2 мянган малчин хамрагдаж, тэтгэврийн даатгалын санд 110.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, улмаар сангаас улмаар сангаас эхний жилд 5.6 мянган малчин тэтгэвэр тогтоолгож наад зах нь 46.6 тэрбум төгрөгийн зарлага гарах тооцоололтой байна. Энэхүү тэтгэврийн даатгалын сангийн зарлагыг жил бүр олгох юм.

Малчны тэтгэврийг бодохдоо нийгмийн даатгалын сангаас олгож байгаа бүрэн тэтгэврийн доод хэмжээ буюу 689,000 төгрөгөөр тооцсон.

Малчны нөхөн даатгалын арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд тэтгэврийн даатгалын сангийн шимтгэлийн орлого зарлагын зөрүү эхний жилд 63.6 тэрбум төгрөг байхаар байна.

---оОо---